


ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ


НЭГ. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2024 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс 2025 оны өдрөөс 09 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар буюу эпидемиологийн 1-38 дугаар долоо хоногт нийт Нийслэлийн 7 дүүрэг, 8 аймагт **1468** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан.



Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 1468 тохиолдлын 94% /1388/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 6% /80/ нь орон нутагт (Баян-Өлгий /30/, Дорнод /3/, Орхон /11/, Өмнөговь /9/, Сэлэнгэ /6/, Төв/16/, Дорноговь /4/, Баянхонгор /1/) бүртгэгдсэн байна.




Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу **384** тохиолдол Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.

ЭПИДЕМИОЛОГИЙН 38 ДУГААР ДОЛОО ХОНОГТ

(2025.09.14 – 09.20)

2025 оны эпидемиологийн 38 дугаар долоо хоногт 38 угаарын хийн хордлого бүртгэгдсэн байна. Өмнөх оны мөн үеэс 35.7 хувиар өсөж, 5 жилийн дунджаас 5.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ

Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд эпидемиологийн 1-38 дугаар долоо хоногт нийт 991 иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.


566
Эмнэлэгийн тусламж авч буцсан

425
Хэвтэн эмчлүүлж эдгэрч гарсан

0
Нас барсан


Эрэгтэй **45%**

Эмэгтэй **55%**



Химийн хордлогыг насны бүлгээр авч үзвэл 0-9 буюу бага насны хүүхдүүд хамгийн их хордлогод өртөж байна.

2025 оны **эпидемиологийн 38 дугаар долоо хоногт** химийн цочмог хордлогод өртсөн **24** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеээс 4 хувиар буурч, сүүлийн 5 жилийн дунджаас 52 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (Эпи – 38 долоо хоногт)

№	Шалтгаан (Сэдэл)	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	1	6	7
2	Эмийн хордлого	8	9	17
Нийт		9	15	24

Нийт хордлогын 70.8%-ийг эмийн, 29.2%-ийг химийн бодисын хордлого эзэлж байна. Санамсаргүй хордлого 62.5%-ийг эзэлж, санаатай хордлого 37.5%-иар бага байна. Иймээс эмийн болон ахуйн бодисын хэрэглээ, хадгалалтын аюулгүй байдлыг сайжруулах нь эрсдэлийг бууруулах гол чиглэл болох боломжтой.

-ооо-